



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Аудитын код: БНА-2025/21-03-ШТА-НА

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ТӨСВИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН САХИЛГА БАТ САЙЖИРЧ, ЗАРДАЛ ХЭМНЭХ, ТӨСВИЙН
ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ТОДОРХОЙ АХИЦ ГАРСАН БАЙНА.

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр	Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор Н.Батчимэг Утас: 99061429 цахим хуудас: Batchimegn@audit.gov.mn Аудитор Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 цахим хуудас: Bunchinsuren@audit.gov.mn Аудитор Д.Цэдэвцэвээн Утас: 89204984 цахим хуудас: Tsedevtseveend@audit.gov.mn Аудитор Г.Энхзул Утас: 99333147 цахим хуудас: Enkhzulg@audit.gov.mn Аудитор Ц.Дорж Утас: 88114307 цахим хуудас: Dorjts@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА	
Тайланг хянасан	Аудитын зорилт, АРГА зүй, СТАНДАРТЫН ТАЛААРХ мэдэгдэл.....3
Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат	Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх 3
Аудитын менежер М.Алтантуяа	Аудитын зорилт 3
	Аудитын хамарсан хүрээ..... 3
	Аудитын арга зүй..... 3
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт..... 4
	Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн..... 4
	Товчилсон үгийн тайлбар..... 5
	Ерөнхий боловсролын сургууль 5
Тайланг бэлтгэсэн	Бүлэг А. төрийн хэмнэлтийн хуулийН холбогдох заалтыг ЗАРИМ байгууллага бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.....6
Ахлах аудитор Н.Батчимэг	А.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс өмнөх оны зөрчил давтагдан гарсаар байна.....6
Аудитор Н.Бүнчинсүрэн Д.Цэдэвцэвээн Г.Энхзул Ц.Дорж	А.1.1.5 дугаар зүйл. Тэргүүн дэд, дэд, орлогч дарга.....6
2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр	А.1.2.6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл.....6
Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.open.audit.mn	А.1.3. 7 дугаар зүйл. Албан тасалгаа.....8
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.	А.1.4. 8 дугаар зүйл. Дүрэмт хувцас.....8
ХАЯГ: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Аймгийн ЗДТГ-ын байр, Баянхонгор сум, Баянхонгор аймаг-64000 Монгол Улс	А.1.5. 9 дүгээр зүйл. Албан томилолт.....9
	А.1.6. 10 дугаар зүйл. Цалин хөлс нэмэгдэл.....9
	А.1.7. 11 дүгээр зүйл. Нэг удаагийн мөнгөн тэтгэмж.....9
	А.1.8. 12 дугаар зүйл. Бусад хангамж.....9
	А.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг ЗАРИМ төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага бүрэн хэрэгжүүлээгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.....10
	Бүлэг Б. Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.....11
	Б.1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдэхгүй байна.....11
	Аймгийн хэмжээнд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд 20,188,973.8 мянган төгрөгийн 166 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж 125 төсөл арга хэмжээнд 16,406,665.2 мянга, 2024 онд 64,367,782.7 мянган төгрөгийн 183 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж 171 төсөл арга хэмжээнд 58,932,921.8 мянган төгрөгийн гэрээг тус тус байгуулан ажилласан байна.....12
	Б.2. Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулж ажиллаагүй байна.....13
	Бүлэг В. Засгийн газар болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн ЗАРИМ АРГА хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн байна.....14
	В.1. Холбогдох байгууллагууд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлснээр тус хуультай холбоотой зөрчил буурсан байна.....14
	В.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр төсвийн байгууллагуудын санхүүгийн сахилга бат сайжирч, зардал хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд тодорхой ахиц гарсан байна.....15
	В.3. Шилэн дансны тухай хуулийг ЗАРИМ байгууллагууд бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.....16
	Аудитын дүгнэлт.....17
	Аудитын зөвлөмж.....18
	УАГ-ын ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ.....ERROR! BOOKMARK NOT DEFINED.

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, МЕУА-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалын дагуу аудитыг гүйцэтгэв.

Аудитын зорилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв: Үүнд

-Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу.

-Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу.

-Засгийн газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу.

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг Баянхонгор аймгийн Засаг даргын 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудит, “Улс орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудиттай уялдуулан, төсөвт байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэв. Хууль хяналтын байгууллага болон шүүхээр хянан хэлэлцэгдэж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.

Аудитын арга зүй

Аудитаар АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав.Үүнд:

- Монгол Улсын 2022, 2023, 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- МУИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам.
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2021 оны 124 дугаар тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга, хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”.
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөл зохиох норм ба дүрэм стандарт
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд
- Батлагдсан зураг төсөл, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер М.Алтантуяа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Батчимэг, аудитор Н.Бүнчинсүрэн, Д.Цэдэвцэвээн, Г.Энхзул, Ц.Дорж нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлж, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 04 дүгээр сарын 24-ний өдрүүдэд гүйцэтгэсэн ба тайлагналын үе шатны ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлүүлж, тайланг Дарга, түргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан 2025 оны 05 дугаар сарын 09-ний дотор УАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ-ын дарга болон аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

	Товчилсон үгийн тайлбар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХО	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦТХХК	Цахилгаан түгээх хариуцлагатай хувьцаат компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

БҮЛЭГ А. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ЗАРИМ БАЙГУУЛЛАГА БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

А.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэлтэй холбоотой хязгаарлалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс өмнөх оны зөрчил давтагдан гарсаар байна

А.1.1.ТХТХ-ийн 5 дугаар зүйл. Тэргүүн дэд, дэд, орлогч дарга

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хуулийн 5.1, 5.2, 5.3, 5.4-т заасан зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд болон тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоог 2023, 2024 онуудад шинээр бий болгоогүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Байгууллагын 2025 оны бүтэц орон тоо, цалинг шинэчлэн тогтоох тухай” А/01 дүгээр тушаалаар Засаг даргын орон тооны зөвлөх баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3¹, 5.4² дэх заалтыг зөрчсөн тул зөвлөхийн чиг үүрэгтэй албан тушаалын орон тоо бий болгосон үйлдлийг таслан зогсоож, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

А.1.2. ТХТХ-ийн 6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/280 дугаар тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталж бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мөрдөж ажиллахыг үүрэг болгосон байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгслийн хязгаарлалттай холбоотой 2023 онд 212,699.3 мянган төгрөгийн 5 зөрчил илэрч 3,019.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 209,680.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 2024 онд 55,000.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч 55,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 24 байгууллагын 75 тээврийн хэрэгслийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-т заасны дагуу улсын дугаарыг тод дэвсгэр өнгөтэй дугаараар солих албан шаардлага өгсөн боловч 22 тээврийн хэрэгслийг тод дэвсгэр өнгөтэй дугаараар солиогүй хэрэгжилт 71 хувьтай байна.

Өмнөх онуудад зөвхөн суудлын авто машиныг хамруулан аудитын горим сорил хэрэгжүүлдэг байсан бол 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Баянхонгор аймгийн төрийн болон орон нутгийн хуулийн этгээдэд ашиглагдаж байгаа бүх төрлийн 884 машин, механизм, мотоциклийг хамруулан шалгасан.

Төрийн болон орон нутгийн өмчит 102 байгууллагын санхүүгийн тайланд 2024 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй суудлын автомашин 181, бусад тээврийн хэрэгсэл 370,

¹ Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно.

² Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно.

мотоцикль 333 нийт 26,124,156.4 мянган төгрөгийн 884 тээврийн хэрэгсэл ашиглагдаж байна.

Хүснэгт №1 Аймгийн төсөвт байгууллагуудын тээврийн хэрэгслийн судалгаа (тоогоор)

д/д	Байгууллагын нэр	2024			
		Суудлын	Бусад	Мотоцикль	Нийт
1	Аймгийн ЗДТГ	8	2	3	13
2	Аймгийн ИТХ	5	6		11
3	Байгаль орчныг хамгаалах алба	1	5	35	41
4	Боловсролын байгууллага	3	5	1	9
5	гамшгаас хамгаалах алба	6	38		44
6	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага	18	12		30
7	Мал эмнэлгийн газар	4	20	20	44
8	Соёлын байгууллага	2	12		14
9	Сумдын ЗДТГ	47	129	186	362
10	Сумдын ИТХ	6	3	2	11
11	Татварын алба	2			2
12	Тусгай зориулалтын авто тээврийн хэрэгсэл	1	4		5
13	Хот тохижилт, нийтийн аж ахуйн үйлчилгээ	14	54	10	78
14	Хүүхэд хамгааллын байгууллага	1	3		4
15	Цагдаагийн алба	27	22	6	55
16	Шүүх шинжилгээний алба		2	1	3
17	Шүүх, прокурорын байгууллага	6			6
18	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	3	3		6
19	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	27	50	69	146
	Нийт дүн	181	370	333	884

Эх сурвалж: Аймгийн Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн судалгаа

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар татан төвлөрүүлэх 78 тээврийн хэрэгслээс 5 сумын 209,680.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 8 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлээгүй зөрчилд аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлсэн ба 49,200.0 мянган төгрөгийн 2 тээврийн хэрэгслийг акталж, 160,480.0 мянган төгрөгийн 6 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлээгүй, 2024 онд 60,500.0 мянган төгрөгийн 3 тээврийн хэрэгсэл нийт 220,980.0 мянган төгрөгийн 9 тээврийн хэрэгслийг ашиглаж байгаа нь ТХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.5 дах заалтуудтай нийцэхгүй байна.

Хүснэгт №2 Татан төвлөрүүлээгүй тээврийн хэрэгсэл судалгаа (мян.төг)

№	Байгууллагын нэр	Загвар /Тухайлбал Toyota Land cruiser-200/	Улсын дугаар	Худалдан авсан огноо	Санхүүгийн тайланд бүртгэлтэй	
					Тоо	Дүн
1	Гурванбулаг сумын соёлын төв	Toyota Haice	1373 БНХ	2019.12.30	1	28,000.0
2	Баянхонгор сумын Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор	Соната-7	3541 БНН	2016.05.31	1	5,000.0
3	Баянлиг сумын Соёлын төв	Микро автобус	2911 БНХ	2019.03.14	1	27,500.0
4	Баян-Овоо сумын ЕБС	УАЗ, 220695	0097 БНН	2021.12.20	1	25,000.0
5	Эрдэнэцогт сумын ЕБС	УАЗ пургон	2823 БНХ	2015.03.30	1	28,000.0
6	Хүрээмарал сумын ЭМТ	УАЗ HUNTER	93-13 БНХ	2017.06.19	1	28,000.0
7	Гурванбулаг ЗДТГ	УАЗ /Фермер/	29-75 БНА	2011.09.24	1	20,480.0
8	Хүрээмарал сумын соёлын төв	Toyota Haice	03-87 БНХ	2021.03.01	1	24,000.0
9	Баян-Овоо сумын ЗДТГ	УАЗ-22092	98-90 БНР	2021.12.31	1	35,000.0
	Нийт дүн					220,980.0

Эх сурвалж: Өмнөх болон тайлант оны аудитын илрүүлэлт

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн хэмжээнд 26,124,156.4 мянган төгрөгийн 884 тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэйгээс 2,634,215.0 мянган төгрөгийн 103 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгөтэй дугаараар солиогүй тул дээрх зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газар хүргүүлэв.
- Улсын бүртгэлийн гэрчилгээгүй, дугаар аваагүй 669,446.6 мянган төгрөгийн 27 тээврийн хэрэгсэл байгаа нь Авто тээврийн тухай хууль 17 дугаар зүйлийн 17.1 дэх “Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ”, Төрийн хэмнэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэсэн заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.
- Албан тушаалын суудлын авто машин 220,980.0 мянган төгрөгийн 9 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

А.1.3. ТХТХ-ийн 7 дугаар зүйл. Албан тасалгаа

Тус онд орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд захирагааны зориулалттай барилга, байгууламж барихад хөрөнгө зарцуулаагүй байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн 11 байгууллагын даргын албан өрөөний талбайн хэмжээ нь дээрх Засгийн газрын тогтоолд заасан хэмжээнээс илүү байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална” гэсэн байгаа ч дээрх Засгийн газрын 2002 оны “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг” 120 дугаар тогтоолыг шинэчлэн батлаагүй тул дээрх илүү талбайн хэмжээг зөрчлөөр тооцох боломжгүй болно.

А.1.4. ТХТХ-ийн 8 дугаар зүйл. Дүрэмт хувцас

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг зөрчиж 2023, 2024 оны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 14,196.3 мянган төгрөгийн зөрчил илэрч 5 төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

- Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар хурлын нарийн бичгийн даргын 2023 оны А/11 дугаар тушаалаар сумын ИТХ-ын төлөөлөгчдөд 230.6 мянган төгрөгийн биеийн тамирын цамц худалдаж авсан.
- Санхүүгийн тайлангийн 2024 оны аудитаар Шинэжинст сумын ЗДТГ, Галуут сумын Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь төсвийн хөрөнгөөс биеийн тамирын хувцас болон гадуур хүрэм авахад нийт 13,965.7 мянган төгрөгийг зарцуулсан.

А.1.5. ТХТХ-ийн 9 дүгээр зүйл. Албан томилолт

Баянхонгор аймагт агаарын тээврийн нислэг байхгүй бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь заалтыг зөрчиж төсвөөс хөрөнгө зарцуулсан зөрчил илрээгүй болно.

А.1.6. ТХТХ-ийн 10 дугаар зүйл. Цалин хөлс нэмэгдэл

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжээс 5 аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагын цалинг Төлөөлөн удирдах зөвлөл, 2 аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагын цалинг аймгийн Засаг даргын захирамжаар тогтоосон байна.

Хүснэгт №3 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын цалин тогтоосон шийдвэр

№	Хуулийн заалт	Гүйцэтгэх удирдлагын цалин, албан хаагчдын хөлсийг тогтоосон субъект, шийдвэр
1	“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
2	Чандмань Баянхонгор ХК	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
3	“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
4	“Цэвэр хот” ОНӨААТҮГ	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
5	“Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ	Аймгийн Засаг даргын захирамж
6	“Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ	Аймгийн Засаг даргын захирамж
7	Баян өсөх агро ОНӨААТҮГ	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
8	Оточмандал ӨЭМТ	Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлын шийдвэрээр ӨЭМТ-ийн даргын цалинг тогтоосон.
9	Оточномгон ӨЭМТ	
10	Наранмандал ӨЭМТ	
11	Энхбүрд ӨЭМТ	

Эх сурвалж: ТАБ-аас хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын баримтаас

Мөн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчдад олгох цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аас тогтоож мөрдүүлээгүй байгаад 2022 оны аймгийн Засаг даргын төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлсэн боловч одоог хүртэл хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг хэрэгжүүлэн орон нутгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчдын цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоож мөрдүүлэхийг аймгийн ИТХ-д толилуулав.

А.1.7. ТХТХ-ийн 11 дүгээр зүйл. Нэг удаагийн мөнгөн тэтгэмж

Тус онд төрийн албан хаагчдад тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг хуульд заасан үндэслэл хэмжээгээр төлөвлөн олгосон байна.

А.1.8. ТХТХ-ийн 12 дугаар зүйл. Бусад хангамж

Бусад хангамжийн зардал болох гар утасны зардал, ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсвэл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал, хэвлэлийн захиалгын төлбөр зэрэг зардлуудыг төсвөөс төлөхөөр төсвийн төсөлд тусгаж төлөвлөөгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг зөрчиж нийт 51,793.3 мянган төгрөгийн 15 зөрчил илэрсэн ба 2023 онд 25,367.3 мянган төгрөгийн 9 зөрчил, 2024 онд 26,426.0 мянган төгрөгийн 6 зөрчил илэрсэн байна.

Хүснэгт №4. Хэмнэлтийн бусад хангамжийн зардалтай холбоотой зөрчлийн нэгтгэл									(мян.төг)
Хуулийн заалт	Зөрчил гаргасан байгууллагын тоо	Албан шаардлага		Зөвлөмж		Төлбөрийн акт		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023 он									

12 дугаар зүйлийн 12.1.1	1					1	435.0	1	435.0
12 дугаар зүйлийн 12.1.4	8	1	19,600.0			7	5,332.3	8	24,932.3
Дүн	9	1	19,600.0	0	0	8	5,767.3	9	25,367.3
2024 он									
12 дугаар зүйлийн 12.1.1	2					4	2,876.0	4	2,876.0
12 дугаар зүйлийн 12.1.4	4	1	3,300.0	1	20,250.0			2	23,550.0
Дүн	6	1	3,300.0	1	20,250.0	4	2,876.0	6	26,426.0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн 2023 оны аудитаар илэрсэн 25,367.3 мянган төгрөгийн 9 шийдвэрийн бүрэн биелүүлсэн бөгөөд 2024 оны шийдвэрийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

A.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд тусгагдсан хэмнэлтийн бусад арга хэмээг зарим төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага бүрэн хэрэгжүүлээгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлтэй холбоотойгоор 2023 онд 42,532.0 мянган төгрөгийн 11 зөрчил илэрч 6,823.0 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт, 34,074.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 1,635.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 2024 онд 108,307.7 мянган төгрөгийн 14 зөрчил илэрч 511.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 104,603.7 мянган 12 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 3,193.0 төгрөгийн 1 зөрчлийг шилжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт №5. Хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зөрчлийн нэгтгэл										(мян.төг)		
Хугацаа	Хуулийн заалт	Зөрчил гаргасан байгууллагын тоо	Албан шаардлага		Зөвлөмж		Төлбөрийн акт		Хуулийн байгууллагад шилжүүлсэн		Нийт	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023	15 дугаар зүйлийн 15.1.3.	5	3	34,074.0	1	1,635.0	3	2,427.0			7	38,136.0
	15 дугаар зүйлийн 15.1.5.	1					1	235.0			1	235.0
	15 дугаар зүйлийн 15.2.3.	2					3	4,161.0			3	4,161.0
	Нийт	8	3	34,074.0	1	1,635.0	7	6,823.0	0	0	11	42,532.0
2024	15 дугаар зүйлийн 15.1.3.	3	5	40,550.8							5	40,550.8
	15 дугаар зүйлийн 15.1.5.	8	6	62,512.9			1	511.0	1	3,193.0	8	66,216.9
	15 дугаар зүйлийн 15.1.6.	1	1	1,540.0							1	1,540.0
	Нийт	14	12	104,603.7	0	0	1	511.0	1	3,193.0	14	108,307.7

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” гэсэн заалтын хүрээнд:

- 15.1.2 Чиг үүрэг, орон тоог давхардуулан шинэ орон тоо албан тушаал батлаагүй;
- 15.1.3. дахь заалтын хүрээнд 2023 онд эмзэгтэйчүүдийн баяр болон тэмдэглэлт өдрүүдтэй холбоотойгоор байгууллагын төсвөөс болон аймаг, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шагнал урамшуулал болон нэг удаагийн тэтгэмж, дэмжлэг олгосонтой холбоотой 38,136.0 мянга, 2024 онд улс төрийн албан хаагч ажлаас чөлөөлөгдөхөд аймаг, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс дэмжлэг үзүүлсэн, байгууллагын төсвөөс гадаадад туршлага судалсан албан хаагчдад

тэтгэмж олгосон, биеийн тамир уралдаан тэмцээний шагнал урамшууллын зардалд нийт 40,550.8 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил тус тус илэрсэн байна.

- 15.1.4. Байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх зорилгоор төсөв батлаагүй.
- 15.1.5. дахь заалтын хүрээнд 2023 онд байгууллагын төсвөөс бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 235.0 мянга, 2024 онд ээлжит сонгууль болсонтой холбогдуулан иргэдийн төлөөлөгч нарт хүндэтгэл үзүүлэхэд зориулан бэлэг дурсгалын зүйл, мөнгөн аяга авахад 54,415.9 мянга, сумын 100 жил, цагаан сар болон ахмадын баяраар бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 11,801.0 мянга нийт 66,216.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.
- 15.1.6 заалтын хүрээнд 2024 онд Баянговь сумын Эрүүл мэндийн төв нь 1,540.0 мянган төгрөгийн 77 ширхэг бичгийн цаасыг нөөцөлсөнд албан шаардлага хүргүүлсэн.
- 15.1.7 Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах зардал төлөвлөж санхүүжүүлээгүй.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана” гэсэн заалтын хүрээнд:

- 15.2.1 дэх заалтын хүрээнд байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2023 онд 445,041.9 мянга, 2024 онд 305,605.7 мянган төгрөгийг хэмнэсэн боловч шинээр ашиглалтад орох барилга хугацаандаа ашиглалтад ороогүй, төсвийг илүү төсөвлөсөн зэрэг шалтгаан нь голлох нөлөө үзүүлж байгаа нь хэмнэлтэд тооцох боломжгүй байна.
- 15.2.2 дахь заалтын хүрээнд төсөвт байгууллагуудын нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжуудын халаалтад тоолуур ашигладаггүй, батлагдсан төсвийн хүрээнд дулаанаар хангах аж ахуй нэгжтэй “Дулаанаар хангах гэрээ” байгуулж, үйлчилгээний чанар харгалзахгүйгээр гэрээний үүргийн дагуу төлбөрөө бүрэн шилжүүлснээс албан хаагчид өвлийн улиралд ажил дээрээ гадуур хувцастайгаа ажиллах, цахилгаан халаагуур ашигласнаар цахилгааны төлбөр нэмэгдэх, мөн цэвэр, бохир усны шугам хөлдсөнөөр ариун цэврийн байгууламж ашиглах боломжгүй болох зэрэг хүндрэл үүсч байна.
- 15.4 дэх заалтын дагуу Чандмань Баянхонгор ХХК-ийн ТУЗ нь гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулсан ба бусад орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн байгууллагын бизнес төлөвлөгөөг баталж дүгнэж байгаа боловч гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулж дүгнээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

• Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулж дүгнэж ажиллаагүй тул цаашид гэрээг байгуулж санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан тохиолдолд гэрээг сунгаж ажиллаж байх зөвлөмжийг ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлүүдэд хүргүүлэв.

БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Б.1. Худалдан авах ажиллагааны 2023-2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 349 төсөл арга хэмжээнээс 125 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь тухайн оны 05 дугаар 31-ний өдрөөс хойш зохион байгуулагдсан байна.

Аймгийн хэмжээнд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд 20,848,141.3 мянган төгрөгийн 166 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж 125 төсөл арга хэмжээнд 15,511,771.3 мянга, 2024 онд 64,996,391.2 мянган төгрөгийн 183 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж 172 төсөл арга хэмжээнд 60,164,450.7 мянган төгрөгийн гэрээг тус тус байгуулан ажилласан байна.

Хүснэгт №6 .Худалдан авах ажиллагааны тайлан (мян.төг)

д/д	Санхүүжилтын эх үүсвэрийн нэр	2023 он				2024 он			
		Батлагдсан төсөл арга хэмжээ		гэрээ байгуулсан		Батлагдсан төсөл арга хэмжээ		гэрээ байгуулсан	
		тоо	төсөвт өртөг	тоо	мөнгөн дүн	тоо	төсөвт өртөг	тоо	мөнгөн дүн
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар					13	34,942,900.0	13	33,967,116.5
2	Гадаадын хөрөнгө оруулалт	1	758,725.8	1	748,665.1				
3	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр	26	8,792,645.6	23	5,799,065.5	20	7,277,338.8	18	6,234,344.2
4	орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар	14	1,756,000.0	14	1,710,900.1	27	6,547,983.0	24	5,860,846.3
5	Сумдын ОНХС	125	9,540,769.9	87	7,253,140.6	123	16,228,169.4	117	14,102,143.7
	Нийт дүн	166	20,848,141.3	125	15,511,771.3	183	64,996,391.2	172	60,164,450.7

Эх сурвалж: Нийцлийн аудитын ажлын баримтаас

13.1.1 дэх заалтын хүрээнд 2023 онд 49 төсөл арга, хэмжээ, 2024 онд 76 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 31-ний өдрөөс хойш зохион байгуулсан дараах шалтгаантай байна.Үүнд:

- Худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулдаг боловч тендерт оролцогч материал ирүүлдэггүй
- Худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуй нэгжүүд нь тендерийн ерөнхий шаардлага хангадаггүйгээс тендер хүчингүй болдог
- Худалдан авах ажиллагаатай холбоотой оролцогчдын ирүүлсэн гомдлыг шийдвэрлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтын үйл ажиллагаа удаарширдаг.Тухайлбал аймгийн ТЕЗ-ийн худалдан авах ажиллагаанд 2023 онд 16, 2024 онд 28 гомдол гарч шийдвэрлэгдсэн байна.

Улс орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар тендер шалгаруулалтаас шалтгаалан Наркологийн төвийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1 “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” хугацаа хэтэрч 2024 оны 9 дүгээр сарын 3- ны өдөр гэрээ байгуулан барилгын ажил эхлүүлсэн байна. Энэ нь барилгын ажил төлөвлөсөн хугацаанаасаа удаашрах шалтгаан болсон тул цаашид худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлийн хууль болон бусад хууль тогтоомжоор заасан хугацаанд багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх зөвлөмжийг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн байна.

13.1.2, 13.1.3-т “Батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулж дуусаагүй, төсөл арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох, худалдан авах ажиллагааны хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэсэн заалтын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээ байхгүй, 2024 онд 34,942,900.0 мянган төгрөгийн 13 төсөл арга хэмжээ батлагдаж 13 төсөл арга хэмжээнд 33,967,116.5 мянган

төгрөгийн гэрээ байгуулж дуусаагүй 8 төсөл арга хэмжээний 776,550.8 мянган төгрөгийг барьцаа дансанд байршуулсан байна.

13.1.4-т “Төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх”, 13.1.6-т “Улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил төрлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргахгүй байх” гэсэн заалтын хүрээнд 2023,2024 онуудад төлөвлөсөн төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсээгүй, өмнө нь ашиглалтад орсон ижил төрлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гараагүй байна.

13.3.3-т “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”-г улсын болон орон нутгийн төсөвт тусгахгүй гэсэн заалтын хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар

- Баянхонгор аймгийн Галуут сумы "Сумын төвийн шинэчлэл" төсөл, арга хэмжээний зураг төсөвгүй байхад 5,000,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, зураг төсөв хийлгэснээр 4,960,800.0 мянган төгрөгийн төсөв нэмэгдсэн,
- Баянхонгор аймгийн Баацагаан сумын "Сумын төвийн шинэчлэл" төсөл, арга хэмжээний зураг төсөвгүй байхад 5,000,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж зураг төсөв хийснээр 6,915,900.0 мянган төгрөгийн төсөв нэмэгдсэн.
- Ингэний сүүний үйлдвэрийн барилгад үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах явцад өргөтгөл хийх шаардлага үүсэж зохиогчийн зөвшөөрлөөр өргөтгөл нэмж барьсан бөгөөд өргөтгөлийн барилгыг гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн гэх боловч төр хувийн хэвшлийн хооронд байгуулсан гэрээ, баримт бичиг байхгүй, төсөв магадлалаар орж байгаа талаар тайлбар ирүүлсэн боловч нотлох баримтгүй тул өргөтгөлийн нэмэгдсэн өртгийг мэргэжлийн байгууллагаар хянан баталгаажуулж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх зөвлөмжийг ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэст тус тус хүргүүлсэн байна.

13.5. дахь заалтын хүрээнд “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн ОНХС-ийн 2,855,800.0 мянган төгрөгийн 44 төсөл арга хэмжээ, 3 сумын 540,600.0 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээ нийт 3,396,400.0 мянган төгрөгийн 53 төсөл арга хэмжээг иргэдийн санал аваагүй аймаг, сумын ИТХ-аар баталсанд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймаг, сумын Засаг даргад хүргүүлсэн байна

Санхүүгийн тайлангийн 2024 оны аудитаар ОНХС-ын иргэдээс санал аваагүй 179,900.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэнд холбогдох 3 байгууллагад зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлсэн ба хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж хуулийн этгээдийн 2024 санхүүгийн тайлангийн аудитаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт дээд хязгаарыг зөрчиж 571,448.6 мянган төгрөгийн 7 төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулсанд зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлсэн ба хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Б.2. Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулж ажиллаагүй байна.

Баянхонгор аймгийн боловсролын системээс бусад төрийн болон орон нутгийн өмчит

хуулийн этгээдүүд нь төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Баянхонгор аймгийн ЕБС-иуд нь Төрийн худалдан ажиллагааны цахим дэлгүүрээс 2022-2024 онуудад 2,345,095.1 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан байна

Харин эрүүл мэндийн салбарын байгууллагууд нь 2018 оноос одоог хүртэл ерөнхий гэрээгээр эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авч байгаа бөгөөд 2024 оны хувьд ерөнхий гэрээгээр 8 компаниас 59,392.1 мянган төгрөгийн 81 нэр төрлийн эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж хуулийн этгээдийн тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах саналыг авч Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 1/63 дугаар албан бичгээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн 2023-2024 онуудад худалдан авсан бараанд тус жагсаалтад багтсан тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа байгаагүй тул Төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жагсаалт хүргүүлээгүй гэсэн тайлбар ирүүлсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийхгүй байгаа нь дараах шалтгаантай байна.

- Цахим дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүн нь зах зээлийн үнээс өндөр үнэтэй
- Ерөнхий гэрээгээр бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа аж ахуй нэгжүүдийн тоо бага байгаагаас сонголт муутай, хэрэглэгчийн тавьсан шаардлагад нийцдэггүй.
- Олон ширхгээр авах тохиолдолд нөөц байдаггүйтэй холбоотой байна.

БҮЛЭГ В. АУДИТААР ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАСНААР ЗӨРЧЛИЙН ТОО ӨМНӨХ ЖИЛЭЭС БУУРСАН БАЙНА.

В.1. Санхүүгийн тайлангийн аудитыг нийцлийн аудиттай хослуулан хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Төрийн аудитын газраас МУЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг мөрдөж, төрийн болон орон нутгийн хуулийн этгээдийн 2022-2024 оны санхүүгийн тайланд аудитыг нийцлийн аудиттай хослуулан гүйцэтгэж 2022 онд 521,749.7 мянган төгрөгийн 71 зөрчил илэрч шийдвэрийн биелэлт 100 хувь, 2023 онд 280,829.2 мянга төгрөгийн 26 зөрчил шийдвэрийн биелэлт 100 хувь, 2024 онд 205,673.2 мянга төгрөгийн 27 зөрчил илэрч шийдвэрийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь хийж гүйцэтгэж буй хяналт шалгалтад хамруулан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тус байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баянхонгор аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар Эрдэнэцогт, Бууцагаан, Бөмбөгөр сумдын ОНХС-аас сумын төвийн айл өрхийн хашаа, гудамж хорооллын өнгө үзэмжийг сайжруулах ажилд 90,000.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-

т “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.2-т “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ” гэсэн заалтыг зөрчсөн тул Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өмчлөл бүртгэх боломжгүй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

В.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр төсвийн байгууллагуудын санхүүгийн сахилга бат сайжирч, зардал хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээгээр ахиц гарсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 77,916,328.8 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 69,931,027.9 мянган төгрөгийг зарцуулж зардлын гүйцэтгэл 89.8 хувь, 2024 онд 108,785,785.6 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 91,829,231.0 мянган төгрөгийг зарцуулж зардлын гүйцэтгэл 84.4 хувьтай байна.

Хүснэгт №7. Аймгийн Засаг даргын 2023-2024 оны төсвийн зардлын төлөвлөгөө гүйцэтгэл (мян.төг)

Д/Д	Он	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	2023	Урсгал	50,390,226.8	46,804,406.0	3,585,820.8	92.9
		Хөрөнгийн	27,526,102.0	23,126,622.0	4,399,480.0	84.0
		Нийт дүн	77,916,328.8	69,931,027.9	7,985,300.9	89.8
2	2024	Урсгал	73,210,487.0	66,569,953.4	6,640,533.6	90.9
		Хөрөнгийн	35,575,298.6	25,259,277.6	10,316,021.0	71.0
		Нийт дүн	108,785,785.6	91,829,231.0	16,956,554.6	84.4

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитад хамрагдах 2023, 2024 онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, байр ашиглалтад холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, хөрөнгийн зардлыг тус тус дутуу зарцуулсан голлох нөлөө үзүүлж байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал хэмнэгдсэн сумдын ЗДТГ-ын мэргэжлийн боловсон хүчин дутагдалтайгаас орон тоо хэмнэгдсэн, тухайн албан тушаалд төрийн албаны шалгалт өгсөн хүн тэнцдэггүй, зарим орон тоог хавсран, хослон гүйцэтгэсэнтэй холбоотой хэмнэлт үүссэн байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэн нь шинээр ашиглалтад орох барилга байгууламж хугацаандаа ашиглалтад ордоггүй, халаалтын улиралд цаг агаар дулаан байсантай холбоотой зарим аж ахуйн нэгж халаалтаа оройтож өгсөнтэй холбоотой байна.
- Эд хогшил, урсгал засварын зардал хэмнэгдсэн нь зарим сумдын татварын орлого дутуу биелэснээс эд хогшил урсгал засварын зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой байна
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал хэмнэгдсэн нь Жаргалант сумын ИТХ, Өлзийт сумын ЗДТГ, Баянбулаг сумын ЗДТГ нь Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлуудыг тус эдийн засгийн ангилалд төлөвлөж зарцуулаагүйтэй холбоотой байна.
- Бараа үйлчилгээний бусад зардал хэмнэгдсэн нь байгалийн давагдашгүй хүчин зүйл бага гарснаас сумдын засаг даргын нөөц хөрөнгө, мөн байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөсөн боловч зарцуулаагүй, хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотойгоор холбогдох бусад зардлыг бага зарцуулсантай холбоотой байна.

Аймгийн Засаг даргын 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зарим зардалд дүн шинжилгээ хийхэд тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмж, ном хэвлэл, нормын хувцас зөөлөн эдлэл өмнөх оноос буурсан үзүүлэлтэй байна.

Хүснэгт №8. Аймгийн Засаг даргын 2023-2024 оны зарим зардлын судалгаа

(мян.төг)

Д/д	Зардлын төрөл	Төсвийн гүйцэтгэл		Өсөлт бууралт
		2023 он	2024 он	
1	Бичиг хэрэг	240,507.6	245,962.7	5,455.13
2	Тээвэр шатахуун	915,791.1	897,954.5	(17,836.60)
3	Албан томилолт	338,420.1	434,636.4	96,216.27
4	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	221,968.5	189,568.9	(32,399.62)
5	Шуудан холбоо	90,481.9	102,728.2	12,246.33
6	Ном хэвлэл	19,491.9	10,682.9	(8,809.00)
7	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,135.0	29,936.7	(1,198.30)
	Нийт дүн	1,857,796.1	1,911,470.3	53,674.2

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төрийн хэмнэлийн тухай хууль хэрэгжсэнээр төсвийн хөрөнгөд тодорхой хэмжээгээр үр ашиг, хэмнэлт бий болсон байна. Үүнд:

- Аймаг, сумдын ОНХС-ын хөрөнгөөр хөшөө дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барих төсөл, арга хэмжээг баталж зарцуулдаг байсан зөрчил бүрэн арилсан.
- Төсөвт байгууллагууд гадаадад туршлага солилцох нэрийдлээр гадаад болон дотоод томилолт, бараа үйлчилгээний бусад зардлаас хөрөнгө батлан зарцуулдаг зөрчил эрс багассан.
- Тээврийн хэрэгсэлийн хязгаарлалт тогтоосноор шинээр авто машин худалдан авах, түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл, жолоочийн цалин хэмнэгдсэн.
- Дүрэмт хувцасны хязгаарлалтыг тогтоосноор төсвийн хөрөнгөөр албан хаагчдад хуульд зааснаас бусад төрлийн дүрэмт хувцас, биеийн тамирын хослол авдаг байдал багассан.
- Хуульд зааснаас бусад үндэслэлээр нэг удаагийн тэтгэмж, урамшууллийг төсвөөс давхардуулан олгодог байдал буурсан.
- Төсвийн хөрөнгөөр гар утасны төлбөрийг төлдөг байдал зогссон.
- Төрийн мэдээлэл болон байгууллагын үндсэн үйл ажиллагаатай шууд холбоотой хэвлэлээс бусад төрийн хэвлэлийн зардлыг төсвөөс зарцуулахаа больсон.
- Сургалт, зөвлөгөөнийг танхимаар зохион байгуулдаг байдал цөөрч цахимаар зохион байгуулж хэвшснээр томилолт, түлш шатахуун, хоол, унаа, бичиг хэргийн зардал тодорхой хэмжээгээр буурсан байна.

В.3. Шилэн дансны тухай хуулийг зарим байгууллагууд бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онуудад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах орон нутгийн өмчит 114 төсөвт байгууллага, 3.1.3-т хамаарах орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах төсвөөс санхүүжилт авч байгаа, 4 өрхийн эмнэлэг, нийт 123 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдаж, мэдээллийг байршуулж иржээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан 267 байгууллагыг хамруулан шалгахад 2023 онд 8,880,259.3 мянган төгрөгийн

84 зөрчил илэрч 8,223,044.1 мянган төгрөгийн 67 албан шаардлага, 511,573.5 мянган төгрөгийн 14 зөвлөмж, 145,641.7 мянган төгрөгийн 3 хариуцлага тооцох албан шаардлага, 2024 онд 4,907,000.9 мянган төгрөгийн 54 зөрчил илэрч 4,907,000.9 мянган төгрөгийн 50 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, хариуцлага тооцох 3 албан шаардлага хүргүүлж ажилласан байна. Шийдвэрийн хэрэгжилт 2023 онд 100 хувь, 2024 оны шийдвэрийн хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Мөн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар 5 сумын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 3,193,700.0 мянган төгрөгийн төлөвлөгөөг нөхөж мэдээлэх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлж, аудитын явцад зөрчлийг арилган ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 -д заасан мэдээллийг дээрх байгууллагууд шилэн дансны нээлттэй цахим хуудсанд хугацаанд нь, ил тод байршуулсан эсэхийг нотлох зүйлсэд үндэслэн тулган шалгаж дараах зөрчлийг илрүүлсэн. Үүнд:

- *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг бүрэн мэдээлээгүй,*
- *Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан,*
- *Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг үнэн зөв, цаг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй зэрэг зөрчлүүд нийтлэг илэрч байна.*

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж хуулийн этгээдүүд нь хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, холбогдох бусад гэрээ, холбогдох шийдвэрийг шилэн дансны цахим сайтад байршуулахгүй байгаа зөрчил давтан гарч байна.

Аудитын илрүүлэлт:

• *Шилэн дансны цахим сайтад хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа болон холбогдох холбогдох бусад гэрээ, шийдвэрийг байршуулж байх, шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт хүргүүлэв.*

Аудитаар нийт 890,426.6 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрч, 890,426.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 3 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд 238,297.2 мянган төгрөгийн 15 зөрчил, 2024 онд 97,365.5 мянган төгрөгийн 13 зөрчил илэрсэн байна.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг зарим төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын дотоод хяналтын тогтолцоо сул байгаагаас хуулийн хэрэгжилт хангалтгүй, өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.
3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд оролцогч оролцдоггүй, тендерийн ерөнхий шаардлага хангаагүйгээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болох, оролцогчдоос ирүүлсэн гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой худалдан авах ажиллагаа удаашрах эрсдэл үүсэж байна.
4. Цахим дэлгүүрээс бараа, бүтээгдэхүүн худалдан авах орчин нөхцөл хангалттай бүрдээгүйгээс сонголт муу, үнэ өндөр, хэрэглэгчдийн шаардлагад нийцэхгүй зэрэг

нь худалдан авагч байгууллагуудад хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байна.

5. Холбогдох байгууллагууд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлснээр тус хуультай холбоотой зөрчил буурсан байна.
6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр төсвийн байгууллагуудын санхүүгийн сахилга бат сайжирч, зардал хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд тодорхой ахиц гарсан байна.
7. Шилэн дансны цахим сайтад зарим байгууллагууд хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, холбогдох бусад гэрээ, холбогдох шийдвэрийг бүрэн байршуулахгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ИТХ-Д ТОЛИЛУУЛАХ НЬ

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтад заасны дагуу төрийн болон орон нутгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчдад олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоон мөрдүүлэхэд анхаарлаа хандуулна уу.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА

1. Аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар Засаг даргын орон тооны зөвлөхийн баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4 дэх заалттай нийцээгүй байгаа тул хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж хуулийн этгээдийн тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах саналыг авч Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ГУРАВ. ОНӨААТҮГ-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулж, гэрээнд заасан санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан тохиолдолд гүйцэтгэх захирлын гэрээг үндсэн гэрээний хугацаагаар сунгаж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу, зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

_____оОо_____